



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Г **Журам батлах тухай** Г

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3-ын 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2000 оны 3 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм"-ийн "нэг" дэх хэсгийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа тооцох журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Ц.Алтанцэцэг)-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ



## ДААТГУУЛАГЧИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН ХУГАЦАА ТООЦОХ ЖУРАМ

1. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос батлан мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг сард шилжүүлэн тооцоход энэхүү журмыг баримтална.

2. Ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс олгож, уг цалин, хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн дараах тохиолдолд тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг энэ журмын 4-т заасны дагуу тооцно. Үүнд:

а/ Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Нийтийг хамарсан ажил зохион байгуулах” журмын 4.16, 4.17-д заасны дагуу нийтийг хамарсан ажилд оролцож хөдөлмөрийн хөлс авсан;

б/ Цагаар ажилласан;

в/ Тухайн сарын нийт өдөр бүтэн ажиллаагүй;

г/ Тогтоосон нормын дагуу гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд тохируулан цалин хөлс олгосон;

д/ Баг (хороо)-ийн иргэдийн нийтийн хурлын дарга нарт Засаг даргын сарын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал сар тутам олгосон;

е/ Бусад (дүүргийн хэсгийн ахлагч нарт олгосон урамшуулал гэх мэт).

3. Үндсэн ажлаас гадна энэ журмын 2-т заасан ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж бодоход шимтгэл төлсөн тухайн цалин, хөлс, орлогыг нэгтгэн тооцно.

4. Энэ журмын 2-т дурдсан даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг сарын цалин, хөлсийг нь үндэслэн дор дурдсанаар тооцно. Үүнд:

а/ Даатгуулагчийн тухайн сарын орлогыг Засгийн газраас баталсан цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хувааж тухайн сард ажилласан нийт цагийг тодорхойлно.

б/ Даатгуулагчийн тухайн сард ажилласан нийт цагийг 8 цаг (ердийн ажлын өдөрт ажиллах хугацаа)-т хувааж, тухайн сард ажилласан ажлын өдрийг тодорхойлно.

в/ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс авсан сар бүрийн ажилласан ажлын өдрийг энэ аргачлалын 4-ийн “а”, “б”-д заасны дагуу тодорхойлж, гарсан хугацааг нэмж, тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааг сар, өдрөөр тодорхойлно.

Тухайлбал, даатгуулагчийн цалин, хөлснөөс дараах байдлаар шимтгэл төлсөн бол түүний шимтгэл төлсөн нийт хугацааг сард шилжүүлэн тодорхойлбол:

№	Үзүүлэлт	2012 онд ажилласан сарууд					2013 онд ажилласан сарууд					Нийт
		2	3	6	11	12	5	6	10	11	12	
1	Цалин хөлс /мян.төг/	90,0	115,0	135,0	95,0	125,0	120,0	140,0	110,0	160,0	180,0	
2	Ажилласан нийт цаг	цалин хөлс : 835 төг 71 мөн						цалин хөлс : 1142 төг 85 мөн			1 378	
		108	138	162	114	150	144	168	96	140	158	
3	Ажилласан ажлын өдөр	Ажилласан нийт цаг : 8 цаг										
		14	17	20	14	19	18	21	12	18	20	173
4	Нийт	ажилласан ажлын өдөр : 21.2										8 сар 3 өдөр

Даатгуулагчийн 2012-2013 оны шимтгэл төлөлтийг энэ журмын дагуу сард шилжүүлэн тооцвол даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг 8 сар 3 хоног болж байна. Энэ хугацааг үндэслэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтооно.

----- оОо -----